



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мөст сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2025/086НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2025 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn</p> <p>Аудитор: Д.Мөнхтулга Утас:70432545 Цахим хаяг: munlhtulgad@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2025-01-30 № 2/03
танай _____-ны № _____-т

МӨСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Х.СОЁЛМАА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мөст сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мөст сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн дүн нь гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг байдлын дүнгээс хэтэрсэн,
- Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжүүлээгүй,
- Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг үр дүнг тооцоогүй, түлээ нүүрс, шатахууны тооцоог бүрэн бодоогүй, зарцуулалтад тавих хяналтгүй,
- Тайлант оны санхүүгийн тайланд тусгасан авлага, өглөг, бараа материал, үндсэн хөрөнгийг зөрүүтэй тусгасан зэрэг алдаа, зөрчлүүд байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" , 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, ер төлбөр үүсгэхгүй байх" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-д "тооллогын комисс дараах үүрэгтэй: эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэсэн заалтуудыг мөрдөөгүй иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын тогтоолоор төрийн захиргааны албан хаагчдад 5 жилийн мөнгөн урамшуулалд 43.0 сая, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад хөдөө орон нутгийн нэмэгдэлд 131.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс олгожээ.

Аудитын гол асуудал

Тайлант онд улс, аймаг, сумын хөрөнгө оруулалтаар 699.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Мөст сумын Засаг даргын тамгын даргын нягтлан бодох бүртгэлд тавих хяналт сул, түлээ нүүрс, шатахуун зарцуулалтын тайлангийн үнэн зөв байдал хангалтгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Адапт төслөөр Боорж гол дагуу 40 га талбайд татмын ойжуулалт, тармаг ойн нөхөн сэргээлтийн ажлыг 441.2 сая төгрөгийн санхүүжилтээр, сумын ЗДТГ-аас Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас төслийн оролцоонд 71.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон, төслийн 3 жилийн хугацаатай 2026 онд дуусгах гэрээ байгуулсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>46,628,461.00</u>	<u>163,235,934.00</u>
33	АВЛАГА	5,000,000.00	112,969,123.00
335	Бусад авлага	5,000,000.00	112,969,123.00
3351	Байгууллагаас авах авлага	5,000,000.00	103,426,323.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	9,542,800.00
35	БАРАА МАТЕРИАЛ	41,628,461.00	50,266,811.00
354	Хангамжийн материал	41,628,461.00	50,266,811.00
35410	Бичиг хэргийн материал	388,710.00	914,810.00
35420	Аж ахуйн материал	7,540,427.00	14,726,427.00
35430	Сэлбэг хэрэгсэл	5,318,500.00	5,318,500.00
35440	Түлш, шатах тослох материал	7,236,214.00	5,030,214.00
35450	Барилгын засварын материал	3,214,950.00	7,114,950.00
35470	Бусад хангамжийн материал	17,929,660.00	17,161,910.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,964,577,845.99</u>	<u>2,561,235,539.30</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,964,577,845.99	2,561,235,539.30
392	Биет хөрөнгө	1,851,550,862.69	2,448,242,480.99
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,093,786,443.23	2,606,794,763.23
39202	Хуримтлагдсан элэгдэл	(692,941,072.18)	(786,699,429.64)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	377,830,950.00	499,330,950.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(92,735,116.40)	(110,311,157.04)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	155,433,380.00	181,063,880.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(90,581,912.00)	(101,400,496.65)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	150,010,964.00	190,448,964.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(49,252,773.96)	(54,984,992.91)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	2,559,500.00	2,559,500.00
39212	Хуримтлагдсан элэгдэл	(2,559,500.00)	(2,559,500.00)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	-	24,000,000.00
393	Биет бус хөрөнгө	113,026,983.30	112,993,058.31
39301	Программ хангамж	2,714,000.00	2,714,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,969,016.70)	(2,002,941.69)
39303	Бусад биет бус хөрөнгө	112,282,000.00	112,282,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,011,206,306.99</u>	<u>2,724,471,473.30</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>213,567.47</u>	<u>27,711,955.59</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	213,567.47	27,711,955.59
413	Өглөг	213,567.47	27,711,955.59
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	213,567.47	372,784.63
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	187,347.96
4136	Бусад өглөг	-	27,151,823.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	12,781,323.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	14,370,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,010,992,739.52</u>	<u>2,696,759,517.71</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,010,992,739.52	2,696,759,517.71
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	695,532,945.00	695,532,945.00
51101	Өмч: - төрийн	695,532,945.00	695,532,945.00
512	Хуримтлагдсан үр дүн	660,345,295.70	1,346,112,073.89
51210	Өмнөх үеийн үр дүн	660,345,295.70	658,861,335.70
51220	Тайлант үеийн үр дүн	-	687,250,738.19

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	655,114,498.82	655,114,498.82
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,011,206,306.99</u>	<u>2,724,471,473.30</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,340,981,786.00	1,839,630,081.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	621,073,266.00	777,548,620.00
120	Нийтлэг татварын бус орлого	621,073,266.00	777,548,620.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	621,073,266.00	777,548,620.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	744,500.00	870,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	620,328,766.00	776,678,620.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	719,908,520.00	1,062,081,461.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,644,620.00	59,029,561.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	36,711,836.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,710,620.00	22,317,725.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,934,000.00	-
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	679,263,900.00	1,003,051,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	679,263,900.00	1,003,051,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	763,973,447.95	1,152,379,342.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	763,973,447.95	1,152,379,342.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	744,152,610.44	1,076,605,881.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	418,141,100.85	664,004,554.21
210101	Үндсэн цалин	210,007,611.97	372,099,081.70
210102	Нэмэгдэл	110,504,193.70	237,341,382.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	8,711,304.00	30,702,090.00
210105	Гэрээт ажлын хөлс	88,917,991.18	23,862,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,080,874.67	82,032,032.58
210201	Тэтгэврийн даатгал	35,532,415.34	55,381,821.73
210202	Тэтгэмжийн даатгал	4,180,284.04	6,666,445.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,344,227.55	3,930,766.75
210204	Ажилгүйдлийн даатгал	820,358.93	3,210,599.71
210205	Эрүүл мэндийн даатгал	8,203,588.81	12,842,398.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,047,125.44	37,676,930.26
210301	Гэрэл, цахилгаан	8,202,076.24	10,724,480.26
210302	Түлш, халаалт	12,845,049.20	26,952,450.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,315,802.50	65,013,872.00
210401	Бичиг хэрэг	3,917,900.00	2,694,002.00
210402	Тээвэр, шатахуун	32,377,505.00	44,408,770.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,943,400.00	2,636,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,530,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	5,076,997.50	13,744,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,926,800.00	952,850.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,995,000.00	-
210604	Урсгал засвар	931,800.00	952,850.00
2107	Томилолт, зочны зардал	8,176,000.00	8,695,600.00
210702	Дотоод албан томилолт	8,176,000.00	8,695,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,886,490.00	6,551,118.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,625,440.00	5,207,138.00
210803	Даатгалын үйлчилгээ	97,950.00	477,640.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	136,000.00	224,660.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	30,000.00	102,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	392,100.00	233,000.00
210807	Газрын төлбөр	2,605,000.00	306,680.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	190,578,416.98	211,678,924.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	78,702,631.50	83,435,798.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	779,000.00	324,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	111,096,785.48	127,919,126.69
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,820,837.51	75,773,461.07
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,938,800.00	43,548,533.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,370,500.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	43,028,533.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	568,300.00	520,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,882,037.51	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,882,037.51	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	17,281,323.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	17,281,323.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	14,943,605.07
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	14,943,605.07
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>577,008,338.05</u>	<u>687,250,738.19</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>577,008,338.05</u>	<u>687,250,738.19</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>726,533,020</u>	<u>1,062,951,461</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	744,500	870,000
120	Нийтлэг татварын бус орлого	744,500	870,000
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	744,500	870,000
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	870,000

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	744,500.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	725,788,520	1,062,081,461
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	679,263,900	1,003,051,900
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	679,263,900	1,003,051,900
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	46,524,620	59,029,561
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000	36,711,836
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,710,620	22,317,725
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,814,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	726,533,020	1,062,951,461
21	УРСГАЛ ЗАРДАЛ	726,533,020	1,062,951,461
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	706,116,182.49	986,193,599.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	418,271,154.32	664,793,066.27
210101	Үндсэн цалин	208,132,909.38	342,655,003.17
210102	Нэмэгдэл	123,888,218.61	269,782,682.35
210104	Урамшуулал	6,988,334.70	30,702,090.00
210105	Гэрээт ажлын хөлс	79,261,691.63	21,653,290.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,419,918.73	81,084,303.36
210201	Тэтгэврийн даатгал	34,981,448.61	55,039,998.34
210202	Тэтгэмжийн даатгал	4,116,923.38	6,483,024.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,790,824.85	5,190,991.74
210204	Ажилгүйдлийн даатгал	1,375,696.85	1,321,299.96
210205	Эрүүл мэндийн даатгал	8,155,025.04	13,048,989.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,725,144.44	32,722,882.30
210301	Гэрэл, цахилгаан	9,420,095.24	10,537,132.30
210302	Түлш, халаалт	13,305,049.20	22,185,750.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,598,155	41,465,300
210401	Бичиг хэрэг	2,684,700	4,328,700
210402	Тээвэр, шатахуун	18,022,755	34,061,000
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,890,700	3,075,600
2105	Нормативт зардал	466,500	447,600
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	466,500	447,600
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,274,500	3,920,700
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	279,600	317,000
210604	Урсгал засвар	5,994,900	3,603,700
2107	Томилолт, зочны зардал	8,176,000	8,695,600
210702	Дотоод албан томилолт	8,176,000	8,695,600
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,793,801.48	17,982,888.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,575,375.48	15,915,808.00
210803	Даатгалын үйлчилгээ	97,950	477,640
210804	Тээврийн хэрэгслийн татвар	197,976	224,660
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	30,000	102,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,287,500	956,100
210807	Газрын төлбөр	2,605,000	306,680
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	162,391,008.52	135,081,260
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	161,691,008.52	133,597,160

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	700,000	1,484,100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,416,837.51	76,757,861.07
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,534,800	44,532,933
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,370,500.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	43,028,533
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,164,300	1,504,400
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,882,037.51	17,281,323
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,882,037.51	17,281,323
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	14,943,605.07
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	14,943,605.07

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	695,532,945	655,114,498.82	660,345,295.70	2,010,992,739.52
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	695,532,945	655,114,498.82	660,345,295.70	2,010,992,739.52
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	695,532,945	655,114,498.82	660,345,295.70	2,010,992,739.52
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	695,532,945	655,114,498.82	660,345,295.70	2,010,992,739.52
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,483,960.00)	(1,483,960.00)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	695,532,945	655,114,498.82	658,861,335.70	2,009,508,779.52
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	687,250,738.19	687,250,738.19
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	695,532,945	655,114,498.82	1,346,112,073.89	2,696,759,517.71

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант он			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	хэмнэлт хэтрэлт	хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,008,217,300	988,978,294.93	19,239,005.07	98.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,008,217,300	988,978,294.93	19,239,005.07	98.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	963,370,300	944,445,361.93	18,924,938.07	98.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	673,619,800	664,793,066.27	8,826,733.73	98.69

210101	Үндсэн цалин	354,976,100	346,062,657.23	8,913,442.77	97.49
210102	Нэмэгдэл	269,952,000	266,375,028.29	3,576,971.71	98.67
210104	Урамшуулал	17,011,700	30,702,090.00	(13,690,390)	180.48
210105	Гэрээт ажлын хөлс	31,680,000	21,653,290.75	10,026,709.25	68.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,205,700	81,084,303.36	3,121,396.64	96.29
210201	Тэтгэврийн даатгал	57,259,800	55,039,998.34	2,219,801.66	96.12
210202	Тэтгэмжийн даатгал	6,736,400	6,483,024.20	253,375.80	96.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,389,200	5,190,991.74	198,208.26	96.32
210204	Ажилгүйдлийн даатгал	1,347,300	1,321,299.96	26,000.04	98.07
210205	Эрүүл мэндийн даатгал	13,473,000	13,048,989.12	424,010.88	96.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,970,100	32,722,882.30	5,247,217.70	86.18
210301	Гэрэл, цахилгаан	11,302,800	10,537,132.30	765,667.70	93.23
210302	Түлш, халаалт	26,667,300	22,185,750.00	4,481,550.00	83.19
2104	Хангамж, бараа материалын зардал	28,809,900	29,138,380.00	(328,480.00)	101.14
210401	Бичиг хэрэг	4,447,400	4,328,700.00	118,700.00	97.33
210402	Тээвэр, шатахуун	21,009,400	21,734,080.00	(724,680.00)	103.45
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,353,100	3,075,600.00	277,500.00	91.72
2105	Нормативт зардал	553,700	447,600.00	106,100.00	80.84
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	553,700	447,600.00	106,100.00	80.84
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,970,700	2,970,700.00	-	100
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	317,000	317,000.00	-	100
210604	Урсгал засвар	2,653,700	2,653,700.00	-	100
2107	Томилолт, зочны зардал	9,684,300	8,695,600.00	988,700.00	89.79
210702	Дотоод албан томилолт	9,684,300	8,695,600.00	988,700.00	89.79
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,304,200	16,073,250.00	230,950.00	98.58
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,106,800	14,006,170.00	100,630.00	99.29
210803	Даатгалын үйлчилгээ	519,000	477,640.00	41,360.00	92.03
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000	224,660.00	75,340.00	74.89
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	102,000	102,000.00	-	100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	968,900	956,100.00	12,800.00	98.68
210807	Газрын төлбөр	307,500	306,680.00	820.00	99.73
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	109,251,900	108,519,580.00	732,320.00	99.33
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	107,767,700	107,035,480.00	732,220.00	99.32
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,484,200	1,484,100.00	100.00	99.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,847,000	44,532,933.00	314,067.00	99.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,847,000	44,532,933.00	314,067.00	99.30
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан	43,102,000	43,028,533.00	73,467.00	99.83

	албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг				
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,745,000	1,504,400.00	240,600.00	86.21
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,008,217,300	988,978,294.93	19,239,005.07	98.09
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,007,612,300	988,108,294.93	19,504,005.07	98.06
132001	Орон нутгийн төсвөөс	1,007,612,300	988,108,294.93	19,504,005.07	98.06
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	605,000	870,000	(265,000.00)	143.80
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605,000	870,000	(265,000.00)	143.80
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	29	29	-	100
620001	Удирдах ажилтан	8	8	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	11	11	-	100
620003	Үйлчлэх ажилтан	3	3	-	100
620004	Гэрээт ажилтан	7	7	-	100

ГУРАВ . АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ :

Аудитаар нийт 296,658.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 280,923.9 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн үндсэн хөрөнгө, бараа материалыг орлогод аваагүй 48,438.0 мянган төгрөгөөр дутуу,
- Авлага 119,747.0, өглөг 9,870.0 мянган төгрөгөөр дутуу,
- Өмнөх оны үйл ажиллагаатай холбоотой гарсан зардлыг 1,483.9 мянган төгрөгийн ажил гүйлгээг тайлант оны зардлаар тусгасан,
- Аймгийн ЗДТГ, сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн өвс тэжээлийн тооцоо бодоогүй аудитын явцад 6,726.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн,
- Тайлант үеийн үр дүнг 94,659.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,

Залруулагдаагүй нийт 15,735.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 15,735.0 мянган төгрөгийн 4 зөрчил² илэрснээс, 4,572.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 11,163.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Тайлант оны төсөвт батлагдаагүй хоолны урамшуулал, албан хаагчдын цалингийн шатлалыг зөрүүтэй тооцон 4,572.0 мянган төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэсэн заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.2.1 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: ЗДТГ-ын спорт заалыг иргэнд түрээслүүлэх гэрээгээр сард 30.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээр тусгасан тайлант онд гэрээг шинэчлээгүй, ЗДТГ-т байрлах буудалд хэчнээн хүн байрлуулсан бүртгэл тооцоогүй тооцоог бодоогүйг нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4.төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх" 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Засгийн газрын 2001 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 134 дугаар "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам"-тай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Заалны түрээсийн орлогын гэрээг шинэчлэн 1 сард төлөх төлбөрийг нэмэгдүүлэх тогтоолтой нийцүүлэн хийх, буудлын тооцоог сар бүр бодож орлогыг тухай бүр төсөвт төвлөрүүлэх

5.2.2 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Газрын нэгдсэн сангийн системд бүртгэлтэй 8407001120, 8407001119, 8407001099, 8407001147 нэгж талбарын дугаар бүхий 469832 м2 газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр олгогдож газар эзэмшүүлэх гэрээ хийгдсэн ч газрыг үнэлж данс бүртгэлд тусгаагүй зөрчил илэрсэн нь УСНББОУС-1, УСНББОУС31 Биет бус хөрөнгө АДБОУС 200,2000, MNS-6817-4:2020 стандартын 7.1.1.2.2, 7.1..3.4, 7.1.3.5 заалтууд болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны "Журам шинэчлэн батлах тухай" 271 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлийн 3.8-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь газар эзэмших эрх шинээр авах саналаа тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан, холбогдох Газрын алба, сумын газрын даамалд хүсэлт гарган шийдвэрлүүлнэ. Газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газрын нэгдсэн системд бүртгэлтэй газруудыг данс бүртгэлд тусгах арга хэмжээг авч ажиллах

5.2.3. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Өдөрт хэчнээн хэмжээний нүүрс, аргал зарцуулдаг нь тодорхой бус, шатахууны тооцоог бүрэн бодоогүй хяналтгүй, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл бодитой бус, байгууллагын удирдлага, санхүүгийн алба, нягтлан бодогчид түлээ, нүүрс болон шатахууны зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4.төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх" 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-д "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн

тайлан тэнцэлд тусгаж тайлагнана." 2/ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/, ", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 02 дугаар сарын 22-ны 65 дугаар тогтоолоор "Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Түлээ нүүрс, шатахууны зарцуулалтад дотоод хяналтыг хэрэгжүүлэх, бараа материалын тооллогыг үнэн зөв хийж үлдээгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан тайланд тусгах

5.2.4 Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш санхүүжилтийн орлого, зарлагын ажил гүйлгээ, дараа жилийн төсвийн төсөл, 2024 оны хагас жилийн санхүүгийн тайлан баланс мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6.1.3-д "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор; 6.1.4.жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор; 6.1.6.төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр., 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр," гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хуульд заасан хугацаанд холбогдох мэдээллийг үнэн зөв байршуулан Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв . Аудитаар илэрсэн буюу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мян.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөст сумын ЗДТГазар	6	280,923.9	4	126,472.7	2	154,451.2	6	280,923.9	-	-
Дүн	6		4	126,472.7	2	154,451.2	6	280,923.9	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мян.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Мөст сумын ЗДТГазар	5	15,735.0	1	4,572.0			4	11163	-	-	-	-
Дүн	5	15,735.0	1	4,572.0	0	-	4	11163	-	-	-	-

ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	-	1	-	-	1	-	-	-
НИЙТ			1	-	-	1	-	-	-